Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Хэрэгжүүлсэн хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин Биелэлт | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. “Салбарын хууль тогтоомж, эрх зүйн бусад актын төсөл боловсруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан салбарын зарим хуульд шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлт оруулах, анхдагч хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааг нэгдсэн зохион | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | Ажлын хэсгүүдийг шинэчлэн байгуулах, ажиллах удирдамж чиглэлийг гаргах. | - Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 1/43 дугаар тушаалаар Эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл “Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажлын хэсгүүдийн ажиллах удирдамжийг тус тус батлуулсан. 2025.03.17, 2025.05.01-ний | I улиралд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулалт, зохицуулалтаар хангах. | | | | өдрүүдэд Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эмнэлгийн мэргэжилтний тухай хуулиудын зохицуулах харилцааны хамрах хүрээг хэрхэн тогтоох талаар ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга болон ажлын хэсэгт орсон яамны албан хаагчдыг хамруулсан хурал зохион байгуулсан.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 сарын 20 өдрийн 181 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгагдсан хуулийн төслийг тогтоолд заагдсан хугацаанд боловсруулах ажлыг хариуцсан чиг үүргийн дагуу зохион байгуулах талаар газар, хэлтсүүдэд дотоод меморандум хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | **Арга хэмжээ 1.2.** Эрүүл мэндийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх. | Дүн шинжилгээний тайлан | - | Бусад орны эрүүл мэндийн хуульд харьцуулсан судалгаа хийсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 1/43 дугаар тушаалаар Эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон ажлын хэсгийн ажиллах удирдамжийг батлуулсан. Ажлын хэсгийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хуралдуулсан. Бусад орны эрүүл мэндийн хуульд харьцуулсан судалгаанд 2025 онд “ХАГАНЭ ЛО ФИРМ ХХК” хуулийн фирмээс хийсэн “Гадаад улс орнуудын эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтын судалгаа”-г ашиглахаар тохиролцон ажиллаж байна. | 2025 оны IV улирал | 70% |
| 3 | **Арга хэмжээ 1.3.** Эмнэлгийн мэргэжилтний тухай анхдагч хуулийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | - | Эмнэлгийн мэргэжилтний тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг хийх, үзэл баримтлалыг батлуулсан байна. | Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дугаар “Аргачлал батлах тухай” тогтоолын 01 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу Эмнэлгийн мэргэжилтний тухай анхдагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг хийсэн. Эмнэлгийн мэргэжилтний тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалыг 2025.05.08-ны өдөр Эрүүл | 2025 оны I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэндийн сайд болон Хууль зүй дотоод хэргийн сайдаар хамтран батлуулсан. | | |
| | **Арга хэмжээ 1.4.** Дархлаажуулалтын тухай, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт холбогдох газар хэлтсүүдтэй хамтран үнэлгээ хийнэ. | Хуулийн хэрэгжилн үнэлгээний тайлан. | - | Хууль тус бүрт үнэлгээ хийх аргачлалыг батлуулах. Үнэлгээ хийх төлөвлөгөөг гаргасан байна. | Дархлаажуулалтын тухай, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт холбогдох газар хэлтсүүдтэй хамтран хүрээнд Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтын дагуу ажлын хэсгийн гишүүдэд танилцуулга мэдээлэл хийсэн. Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудаас хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах ажил хийгдэж байна. | 2025 оны II-III улирал | 70% |
| | **Арга хэмжээ 1.5.** Сайдын тушаал, Төрийн нарийн бичгийн тушаал, холбогдох шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянах, зөвлөгөө, хуульд нийцүүлэх. | Тушаал, холбогдох шийвэрийн төсөлд хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн тоо | | Яамны албан хаагчид хууль, эрх зүйн мэдээлэл болон мэргэжил, арга зүйн туслалцаагаар хангагдсан байна. | Эрүүл мэндийн сайдын батлан гаргасан захиргааны хэм хэмжээний актын 5 төсөл, хэм хэмжээ тогтоогоогүй Эрүүл мэндийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг хянаж, санал, зөвлөгөө өгч ажилласан. | I-IV улиралд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.6.** Яамнаас батлан гаргасан захиргааны хэм хэмжээний актуудын хуульд нийцсэн байдал, тэдгээрийн хоорондын уялдааг хангах, давхардал, зөрчлийг арилгах асуудлыг судлан үзэж, нэгдсэн санал, дүгнэлт боловсруулна. | Дүн шинжилгээ хийсэн шийдвэрийн тоо | | Санал, дүгнэлт боловсруулагдаж ХЗДХЯ-нд хүргэгдсэн байна. | Яамнаас батлан гаргасан нийт 84 захиргааны хэм хэмжээний актуудын хуульд нийцсэн байдал, тэдгээрийн хоорондын уялдааг хангах, давхардал, зөрчлийг арилгах асуудлыг судлан, дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулан дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 1а/1717 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | I улиралд | 100% |
| **ХОЁР. "Салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тайлагнах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** */Албан тушаалын зорилго, зорилтод суурилсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн зорилт/* | | | | | | | |
| 1 | Монгол Улсын нэгдэн орсон эрүүл мэндийн салбарын чиг үүрэгт хамаарах олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг нэгтгэн, хугацаанд нь тайлагнах, хяналт тавих | Холбогдох байгууллагад хүргүүлсэн тайлан | 100% | Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг тайлагнасан байна. | Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар, Эмнэлгийн тусламжийн бодлогын газраас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын олон талт гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх биелэлтийг 2024 оны 359 дугаар дотоод меморандумаар гаргуулан авч нэгтгэсэн.<br>Гадаад харилцааны яамны гэрээ, эрх зүйн газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 2/5632 дугаар албан бичгээр | I-IV улиралд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенци, Тамхины хяналтын тухай суурь конвенцийн хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн. | | |
| 2 | **Арга хэмжээ 2.2.** Эрүүл мэндийн сайд, эрүүл мэндийн яаманд хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Байнгын хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэж, холбогдох газар, хэлтсүүдэд танилцуулах, хэрэгжилт, тайлагналтад хяналт тавих. | Хугацаанд нь тайлагнасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан | - | Тайланг тогтоосон хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн байна. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд газар хэлтсүүдээс авч Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Мөн тайланг өмнөх сарын хэрэгжилтээс хойш гарсан өөрчлөлт, тоо, баримт, санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэр, үр дүнг дурдан товч тодорхой үнэн зөв, бүрэн гүйцэд гарган тайлагнах талаар холбогдох газар, хэлтсүүдэд чиглэл хүргүүлж ажилласан. | I-IV улирал | 100% |
| 3 | **Арга хэмжээ 2.3.** Эрүүл мэндийн яамны болон харьяа байгууллагуудын ХАСХОМ мэдүүлэгчийн 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь баталгаажуулах ажлыг зохион | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан албан хаагчдын хувь | 0% | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бүрэн гаргуулсан байна. | Эрүүл мэндийн яамны болон харьяа байгууллагуудын ХАСХОМ мэдүүлэгчийн 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гарган баталгаажуулсан. | I улиралд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж, тайланг АТГ-т хүргүүлэх. | | | | | | |
| 4 | **Арга хэмжээ 2.4.** Эрүүл мэндийн салбар дахь Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжид холбогдох арга хэмжээг авч ажиллах | Зөвлөмжийн хариуг хүргүүлсэн тоо | 100% | Зөвлөмжийн хариуг хүргүүлсэн тоо | Уг арга хэмжээг 2025 оны сүүлийн хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар:<br>- Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээс Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 2, болон Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Өргөө амаржих газартай холбоотойгоор нийт 5 зөвлөмжийг ирүүлсэн. Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг тухай бүр албан бичгээр хуулийн хугацаанд нь хүргүүлсэн.<br>- Хүний эрхийн Үндэсний Комиссоос “Иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтэд судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалт, үнэлгээ хийх” ажлыг 2025 онд зохион байгуулах гэж буй | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаар Эрүүл мэндийн сайдад танилцуулсан. Үүний дагуу хийгдэх ажлын удирдамжийг ЭМЯ-нд ирүүлсэн бөгөөд судлан санал хүргүүлсэн. | | |
| **ГУРАВ. "Салбарын хууль тогтоомж, эрх зүйн актын мэдээллийн сан бүрдүүлэх, лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг удирдан зохион байгуулах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг хянах, зөвлөгөө өгөх, улсын бүртгэлд бүртгүүлэх | Улсын бүртгэлд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн тоо | 0% | Хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол шийдвэрт нийцсэн байх ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байна. | Эрүүл мэндийн сайдын батлан гаргасан захиргааны хэм хэмжээний актын 5 төслийг хянаж, хуульд нийцүүлэх зөвлөгөө өгсөн. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм батлах тухай А/85, А/55, А/49 дүгээр тушаал, Журам шаардлага шинэчлэн батлах тухай /эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага А/130 А/58 дугаар тушаал, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах заавар шинэчлэн | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батлах тухай А/173 дугаар тушаал,<br>Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай А/189 дүгээр тушаал,<br>Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үйлчлэгч бодис, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журам А/206 дугаар тушаал. | | |
| | Дотоодын аж ахуй нэгж байгууллага, хувь хүнтэй байгуулсан гэрээний бүртгэлийн сан үүсгэх, баяжилт хийх | Тогтмол баяжилт хийсэн гэрээний бүртгэлийн сан | | Гэрээний цаасан бүртгэл үүсгэж, тогтмол баяжилт хийсэн байна. | - Эрүүл мэндийн яамнаас дотоодын аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнтэй байгуулах 2025 оны нийт 138 гэрээг хууль, эрх зүйн хүрээнд хянаж ажиласан.<br>- Гэрээнд тухай бүр дугаар олгож, цаасан хэлбэрээр буюу гэрээний бүртгэлийн дэвтрийг хөтөлж, гэрээний мэдээний санд тогтмол баяжилт хийж байгаа бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн яамны нэр дээр 138 гэрээг бүртгэсэн байна.<br>- Яамны дотоод үйл ажиллагааны хүрээнд 61, хөрөнгө оруулалтын | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд 39, төслийн хүрээнд 38 гэрээ байгуулагдсан байна. | | |
| **ДӨРӨВ. “Хэлтсийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, зохицуулалт” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** */Албан тушаалын зорилго, зорилтод суурилсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн зорилт/* | | | | | | | |
| 1 | Хэлтсийн албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлүүлэхэд хяналт тавьж ажиллах | Хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо | 0 | Албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэхэд байнгын хяналт тавьж арга зүйгээр ханган ажиллаж байна. 2025 оны 06 сарын байдлаар эцэслэн шийдвэрлээгүй, хаагаагүй албан бичиг, өргөдөл гомдол байхгүй байна. | I-IV улирал | |
| 2 | Сайд, Дэд сайд, ТНБД, харьяа газрын даргаас өгсөн чиг үүрэгтэй холбоотой шуурхай үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэхэд хяналт тавих | Нэмэлтээр өгсөн шуурхай үүрэг даалгаварын тоо | 0 | Нэмэлтээр өгсөн үүрэг даалгаварыг хугацаанд нь гүйцэтгэсэн байна. | Эрүүл мэндийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын даргаас өгсөн чиг үүрэгтэй холбоотой шуурхай үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэх болон гүйцэтгэхэд хяналт тавьж байна. Хугацаа хоцроосон үүрэг даалгавар байхгүй байна. | I-IV улирал | 100% |
| 3 | Эрх зүйн маргаанд олгосон итгэмжлэлийн дагуу Эрүүл мэндийн яамыг төлөөлж оролцох | - Яамыг төлөөлөн оролцсон эрх зүйн маргааны тоо | 0 | Шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргаанд оролцсон байна. | Төрийн захиргааны удирдлагын газрын хуулийн хэлтэс 2025 оны байдлаар 6 эрх зүйн маргаанд оролцсож шийдвэрлэсэн байна. | II-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | - Шийдвэрлэгдсэн маргааны тоо | | | | | |
| 4 | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтэд байнгын хяналт тавих, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах | Албан хэрэг хөтлөлттэй холбоотой гарсан зөрчлийн тоо | 0 | Яамны албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна. | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтэд байнгын хяналт тавих, арга зүйгээр хангаж ажиллаж байна. 2025 оны ..... сарын байдлаар эцэслэн шийдвэрлээгүй, хаагаагүй албан бичиг, өргөдөл гомдол байхгүй байна. | I-IV улирал | 100% |
| 5 | Яамны төрийн нууцтай холбоотой үйл ажиллагааг хууль журмын хүрээнд зохион байгуулах | Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн зөрчлийн тоо | 0 | Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжсэн байна. | Нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох албан тушаалтанд танилцуулах, бүртгэлийн дугаар олгох, холбогдох байгууллагад хүргэж өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яамны 2024 онд хийсэн ажлын тайланг Тагнуулын Ерөнхий газарт нууцын журмаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга Л.Баттөр, Стратеги төлөвлөлтийн газрын Эм, эмнэлгийн | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгслийн бодлогын хэлтсийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Л.Намхайноров, албан хаагчдын шилжилт хөдөлгөөнийг ТЕГ-рт энэ оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 2/2746 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Эрүүл мэндийн яам болон харьяа байгууллагад хадгалагдаж байгаа байгаа нууц баримт бичгүүдийг нэгтгэх, Төрийн болон албаны нууцтай харилцах албан хаагчдын нууцын талаарх мэдлэгийг тогтоох, нууцын биет хадгалалт хамгаалалт, 2017 оноос хойш хувийн хэргээр гадаад улсад зорчсон зэрэг мэдээ, мэдээллийг нэгтгэж ТЕГ-рт хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн ТЕГ-аас ирүүлсэн жилийн эцсийн тайлан мэдээг ирүүлэх зааварчилгааг харьяа байгууллагуудад 2025 оны 05 дугаар сарын 23-ны 2/2724 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.<br>Дээрх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлснээр төрийн | | |

| | | | | | болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлсэн нь Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжиж байна. | | |
|---|---|---|---|---|---|---|---|

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Хэрэгжүүлсэн хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Гүйцэтгэл | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 1 | Шинээр гарсан хууль тогтоомжийг тухай бүр судалж, албан хэрэгцээнд ашиглах | Судалж, албан хэрэгцээнд ашигласан хууль тогтоомжийн тоо | 0 | 5-аас доошгүй хууль тогтоомжийг судалсан байна. | Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль, Эрүүгийн хууль зэрэг хуулийг судалсан байна. 5 орны эрүүл мэндийн чиглэлийн эрх зүйн орчны судалгааг хийж 105 хуудас судалгааны тайланг нэгтгэн гаргасан.<br>Тайланг хэвлэлтэнд шилжүүлэгүй байна. | I-IV улирал | 90% |
| 2 | ЭМЯ-ны Харьяа байгууллагуудын хууль эрхзүйн | Зохион байгуулсан сургалтын тоо | 0 | Сургалтыг нэг удаа зохион | | I-IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | асуудал хариуцсан ажилтнуудад сургалт зохион байгуулах | | | байгуулсан байна. | | | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ................................ /Б.ОДГЭРЭЛ/ 2025 оны 06 дугаар сарын 10

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо)*